



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 8/20

Ховд

Г Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Буянт багийн нутаг дэвсгэр Ш.Эрэнцэнгийн 2 дугаар гудамжны 206 тоотод байрлах 2094 метр квадрат газрыг Ховд аймгийн Онцгой байдлын газарт /9067698/ албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Ану хатан 2 дугаар гудамжны 207 тоотод байрлах 1146 метр квадрат газрыг Ховд аймаг дахь Бусийн оношилгоо, эмчилгээний төвд /9066829/ эмнэлгийн зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Магсаржав багийн нутаг дэвсгэр Баянгол 4 дүгээр гудамжны 401 тоотод байрлах 1021 метр квадрат газрыг Тэгш стандарт ХХК /4073444/-нд орон сууцны зориулалтаар 2 жилийн хугацаагаар

4. Жаргалант сумын Бугат багийн нутаг дэвсгэрт байрлах Цэнгэг 12 дугаар гудамжны 1200 тоотод байрлах 2033 метр квадрат газрыг Ховд аймгийн Жаргалант сумын Цэцэгхэн арван тав дугаар цэцэрлэгт /8241848/ боловсролын байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

5. Газар эзэмших эрх нь баталгаажсан дээрх албан байгууллагын дарга, эрхлэгчтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 00086 ZaxA/20 Ch